## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1650000.00** | **2121300.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 1.00 | 836500.00 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | 1.00 | 836500.00 |
| 31110 | Төгрөг | 1.00 | 836500.00 |
| **33** | **АВЛАГА** | 1649999.00 | 1129800.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 400000.00 | 405000.00 |
| **335** | **Бусад авлага** | 1249999.00 | 724800.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1249999.00 | 724800.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 0.00 | 155000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 0.00 | 155000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 0.00 | 155000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **59816585.79** | **69308307.43** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 59816585.79 | 69308307.43 |
| **392** | **Биет хөрөнгө** | 46352585.79 | 55844307.43 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 26779101.94 | 26779101.94 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1834110.80 | -2338776.20 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 20000000.00 | 20000000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -4000000.08 | -6000000.12 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 50653869.00 | 56916769.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -46330300.40 | -48603670.57 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10136531.00 | 18986306.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -9052504.87 | -9895422.62 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 13464000.00 | 13464000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13464000.00 | 13464000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **61466585.79** | **71429607.43** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1410623.53** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1410623.53 | 0.00 |
| **413** | **Өглөг** | 1410623.53 | 0.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1410623.53 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **60055962.26** | **71429607.43** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 60055962.26 | 71429607.43 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 45813171.00 | 45813171.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 45813171.00 | 45813171.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -28894253.12 | -17520607.95 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -28894253.12 | -28894253.12 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 11373645.17 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 43137044.38 | 43137044.38 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **61466585.79** | **71429607.43** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 204,686,930.00 | 219,132,675.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 34,856,230.00 | 50,023,275.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 34,856,230.00 | 50,023,275.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 34,856,230.00 | 50,023,275.00 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 34,856,230.00 | 50,023,275.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 169,830,700.00 | 169,109,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 169,830,700.00 | 166,109,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 169,830,700.00 | 166,109,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 3,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 3,000,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 205,747,337.71 | 207,759,029.83 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 205,747,337.71 | 207,759,029.83 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 182,401,107.71 | 197,244,229.83 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 120,876,782.80 | 129,100,899.00 |
| 210101 | Үндсэн цалин | 90,367,682.80 | 102,398,100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 26,895,600.00 | 21,480,823.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,613,500.00 | 5,221,975.04 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 17,261,274.63 | 17,191,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,376,740.15 | 12,578,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,221,133.62 | 1,153,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 976,686.89 | 922,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 244,446.74 | 230,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,442,267.23 | 2,306,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,500,000.00 | 18,000,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 18,500,000.00 | 18,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,772,700.00 | 7,113,050.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,898,100.00 | 1,250,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,578,100.00 | 3,166,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,156,600.00 | 1,905,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 161,900.00 | 60,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 978,000.00 | 730,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,000,000.00 | 1,620,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,900,000.00 | 1,620,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 100,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,272,050.00 | 4,420,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,472,050.00 | 730,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 800,000.00 | 2,220,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 1,470,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,055,710.00 | 5,896,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,055,710.00 | 5,896,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 718,500.00 | 818,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 132,000.00 | 105,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 132,000.00 | 132,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 50,000.00 | 43,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 16,500.00 | 16,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 8,000.00 | 80,800.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 50,000.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 330,000.00 | 440,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,944,090.28 | 13,084,180.83 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,465,428.00 | 4,184,677.47 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 3,278,550.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 4,478,662.28 | 5,620,953.36 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,346,230.00 | 10,514,800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 17,940,000.00 | 1,604,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,940,000.00 | 944,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 660,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,406,230.00 | 8,910,800.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(1,060,407.71)** | **11,373,645.17** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(1,060,407.71)** | **11,373,645.17** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагд сан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 45,813,171.00 | 43,137,044.38 | -28,894,253.12 | 60,055,962.26 |
| D01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 45,813,171.00 | 43,137,044.38 | -28,894,253.12 | 60,055,962.26 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 45,813,171.00 | 43,137,044.38 | -28,894,253.12 | 60,055,962.26 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 11,373,645.17 | 11,373,645.17 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 45,813,171.00 | 43,137,044.38 | -17,520,607.95 | 71,429,607.43 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **204686930.00** | **219132675.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 34856230.00 | 50023275.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 34856230.00 | 50023275.00 |
| **13** | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | **169830700.00** | **169109400.00** |
| **1310** | Улсын төвлөрсөн төсвөөс | 169830700.00 | 166109400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 169830700.00 | 166109400.00 |
| **1311** | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.00 | 3000000.00 |
| **2** | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | **200948246.00** | **203183501.00** |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | **200948246.00** | **203183501.00** |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | **177602016.00** | **192668701.00** |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 121698200.00 | 129106000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 91189100.00 | 102403100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 26895600.00 | 23089400.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3613500.00 | 3613500.00 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16429300.00 | 17191000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11544765.52 | 12578900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1221133.62 | 1153000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 976686.89 | 922400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 244446.74 | 230600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2442267.23 | 2306100.00 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 18500000.00 | 18000000.00 |
| 210304 | Байрны түрээс | 18500000.00 | 18000000.00 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 6724700.00 | 7131600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1400000.00 | 1291300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3006200.00 | 3044500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1156600.00 | 1905800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 161900.00 | 60000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1000000.00 | 830000.00 |
| **2105** | Нормативт зардал | 2000000.00 | 1620000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1000000.00 | 1620000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1000000.00 | |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 2050050.00 | 4420000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1250050.00 | 900000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 800000.00 | 2220000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 1300000.00 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 7000000.00 | 5896401.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7000000.00 | 5896401.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 888500.00 | 818700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 132000.00 | 105600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 132000.00 | 132000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 50000.00 | 43800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 16500.00 | 16500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 8000.00 | 80800.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 50000.00 | 440000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 500000.00 | |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 2311266.00 | 8485000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1311266.00 | 5935000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1000000.00 | 2550000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **23346230.00** | **10514800.00** |
| **2132** | Бусад урсгал шилжүүлэг | 17940000.00 | 1604000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17940000.00 | 944000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 660000.00 |
| **2133** | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 5406230.00 | 8910800.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5406230.00 | 8910800.00 |
| **3** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | **3738684.00** | **15949174.00** |
| **5** | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | **3738684.00** | **15112675.00** |
| **22** | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | **3738684.00** | **15112675.00** |
| **2200** | Дотоод эх үүсвэрээр | 3738684.00 | 15112675.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3738684.00 | 15112675.00 |
| **6** | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | **-3738684.00** | **-15112675.00** |
| **8** | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 0.00 | 836499.00 |
| **9** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 1.00 |
| **10** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 836500.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 199830700.00 | 199280700.00 | 191659400.00 | 191648300.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 199830700.00 | 199280700.00 | 191659400.00 | 191648300.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 181340700.00 | 181340700.00 | 190055400.00 | 190044300.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 121698200.00 | 121698200.00 | 125304000.00 | 125304000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 91189100.00 | 91189100.00 | 98601100.00 | 98601100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 26895600.00 | 26895600.00 | 23089400.00 | 23089400.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3613500.00 | 3613500.00 | 3613500.00 | 3613500.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16429300.00 | 16429300.00 | 16816000.00 | 16816000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11561300.00 | 11544765.52 | 12203900.00 | 12203900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1217000.00 | 1221133.62 | 1153000.00 | 1153000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 973600.00 | 976686.89 | 922400.00 | 922400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 243400.00 | 244446.74 | 230600.00 | 230600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2434000.00 | 2442267.23 | 2306100.00 | 2306100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18500000.00 | 18500000.00 | 18000000.00 | 18000000.00 |
| 210304 | Байрны түрээс | 18500000.00 | 18500000.00 | 18000000.00 | 18000000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6724700.00 | 6724700.00 | 7131600.00 | 7131600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1400000.00 | 1400000.00 | 1291300.00 | 1291300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3006200.00 | 3006200.00 | 3044500.00 | 3044500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1156600.00 | 1156600.00 | 1905800.00 | 1905800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 161900.00 | 161900.00 | 60000.00 | 60000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1000000.00 | 1000000.00 | 830000.00 | 830000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2000000.00 | 2000000.00 | 1620000.00 | 1620000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1000000.00 | 1000000.00 | 1620000.00 | 1620000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1000000.00 | 1000000.00 | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5100000.00 | 5100000.00 | 8220000.00 | 8208900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4300000.00 | 4300000.00 | 4700000.00 | 4688900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 800000.00 | 800000.00 | 2220000.00 | 2220000.00 |
| 210604 | Урсгал засвар | | | 1300000.00 | 1300000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7000000.00 | 7000000.00 | 6307900.00 | 6307899.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7000000.00 | 7000000.00 | 6307900.00 | 6307899.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 888500.00 | 888500.00 | 745900.00 | 745900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 132000.00 | 132000.00 | 105600.00 | 105600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 132000.00 | 132000.00 | 132000.00 | 132000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 50000.00 | 50000.00 | 43800.00 | 43800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 16500.00 | 16500.00 | 16500.00 | 16500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 8000.00 | 8000.00 | 8000.00 | 8000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 50000.00 | 50000.00 | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 500000.00 | 500000.00 | 440000.00 | 440000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3000000.00 | 3000000.00 | 5910000.00 | 5910001.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2000000.00 | 2000000.00 | 3360000.00 | 3360001.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1000000.00 | 1000000.00 | 2550000.00 | 2550000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 18490000.00 | 17940000.00 | 1604000.00 | 1604000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18490000.00 | 17940000.00 | 1604000.00 | 1604000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18490000.00 | 17940000.00 | 944000.00 | 944000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | | 660000.00 | 660000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 199830700.00 | 204686930.00 | 191659400.00 | 191648300.00 |
| **1310** | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 169830700.00 | 169830700.00 | 166109400.00 | 166109400.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 169830700.00 | 169830700.00 | 166109400.00 | 166109400.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 30000000.00 | 34856230.00 | 25550000.00 | 25538900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30000000.00 | 34856230.00 | 25550000.00 | 25538900.00 |
| **4** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1.00 | -1.00 | | 1.00 |
| **5** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1.00 | -1.00 | 0.00 | 836500.00 |
| **62** | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 11.00 | 11.00 | 11.00 | 11.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 5.00 | 5.00 | 7.00 | 7.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 | 3.00 | 3.00 |

## 2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 0.00 | 18573575.00 |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | 0.00 | 18573575.00 |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 0.00 | 18573575.00 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 0.00 | 3802000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 0.00 | 3802000.00 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 0.00 | 375000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 375000.00 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 0.00 | 11323775.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 4024000.00 |
| 210602 | Тавилга | | 7299775.00 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 0.00 | 425000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 425000.00 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 0.00 | 72800.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 72800.00 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 2575000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 2575000.00 |
| **II** | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.00 | 18573575.00 |
| **1311** | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.00 | 18573575.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 3000000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 15573575.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, гэрээт аудитор К.Риза нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн №13 б/11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн зорилго нь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжүүрийн баталгаажуулалт, сорилт шинжилгээ, чанарын үйл ажиллагааны бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, үйлчилгээ үзүүлэх явдал юм гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Стандарт хэмжилзүйн хэлтсийн газрын Санхүүгийн хэлтсээс сар бүрийн төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажилладаг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 2 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9.9 сая төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 836.5 | 836.5 |
| Авлага | 1650.0 | 1129.8 | 520.2 |
| Бараа материал | | 155.0 | 155.0 |
| Үндсэн хөрөнгө | 59816.6 | 69308.3 | 9491.7 |
| **Нийт хөрөнгө** | **61466.6** | **71429.6** | **9963.0** |
| Өглөг | 1410.6 | | (1410.6) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 60056.0 | 71429.6 | **11373.6** |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **61466.6** | **71429.6** | **9963.0** |

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст 0.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Оны эхэнд байгууллагуудаас авах үйлчилгээний хөлс болон ажилчидтай холбогдсон НДШ-ийн авлага зэрэг 1.6 сая төгрөгийн авлагатай байсан ба тайлант онд 0.5 сая төгрөгийн авлага барагдаж, үйлчилгээний хөлсний 1.1 сая төгрөгийн авлагатай гарчээ.

Бараа материалын дансны үлдэгдэл оны эцэст 0.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн хөрөнгөөр 2.6 сая төгрөгийн бичиг хэрэг, 0.2 сая төгрөгийн аж ахуйн материал, 4.6 сая төгрөгийн түлш шатах тослох материал, 8.9 сая төгрөгийн бусад хангамжийн материал, 1.1 сая төгрөгийн эм боох материал, нийтдээ 18.6 сая төгрөгийн бараа материалыг орлого авч, 18.4 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 71.4 сая төгрөг болж оны эхнээс 9.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдаж авсан үндсэн хөрөнгийн дүн, элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217 тоот тушаалаар Улсын төсвийн байгууллагуудын тайлант хугацаанд төсөвт төвлөрүүлсэн өөрийн орлогын давсан хэсгийг нэмэлт дансанд шилжүүлэн зарцуулах эрх олгосны дагуу 15.6 сая төгрөгийг нэмэлт дансаар дамжуулан тавилга, тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Оны эхэн болон эцэст өр төлбөр гараагүй байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 14.4 сая төгрөгөөр буюу 7 хувиар өссөн нь өөрийн орлогын давсан хэсгээс 15.6 сая төгрөгийг буцаан олгосон мөн тус аймагт зохион байгуулсан Стандарт хэмжилзүйн байгууллагын ажилтнуудын сургалтын арга хэмжээний зардалд зориулан Орон нутгийн орлогын давсан хэсгээс 3.0 сая төгрөгийн дэмжлэг олгосонтой холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 2.0 сая төгрөгөөр буюу 1 хувиар өссөн нь дээрхи сургалт арга хэмжээний зардалтай холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Стандарт хэмжилзүйн газраас оны эхэнд 2021 оны төсвийг 191.6 сая төгрөгөөр батлан төсвийн хуваарь ирүүлжээ.

Төсвийн жилийн дундуур төсөвт өөрчлөлт оруулаагүй байгаа ба батлагдсан төсвийн 166.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 25.5 сая төгрөгийг өөрийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөж, орон тоог 13 орон тоогоор баталжээ.

**Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 166.1 сая төгрөгийн, өөрийн орлогоос 25.5 сая төгрөгийн нийтдээ 191.6 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж, батлагдсан төсвийг 11.1 мянган төгрөгөөр хэмнэж, өөрийн орлогын төлөвлөгөөнөөс илүү оруулсан 8.9 сая төгрөгийн хамт нийтдээ 8.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төлөвлөгөөгөөр өөрийн орлогоос 25.5 сая төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 50.0 сая төгрөгийг баталгаажуулалтын хөлс, үйлчилгээний хөлсний хураамжаас оруулан, 25.5 сая төгрөгийг үйл ажиллагааны төсөвт зарцуулж, 8.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэн, орлогын давсан хэсгийн 15.6 сая төгрөгийг Сангийн сайдын шийдвэрээр нэмэлт санхүүжилтээр зарцуулж байгууллагын хэрэгцээнд тавилга, тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 191.6 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Нийт төсвийн 74.2 хувийг цалин, НДШ-ийн зардал, 9.4 хувийг тогтмол зардал, 3.7 хувийг хангамж бараа материалын зардал, 4.3 хувийг эд хогшил урсгал засварын зардал, 3.3 хувийг томилолтын зардал, 5.1 хувийг бусад бараа үйлчилгээний зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд Орон нутгийн орлогын давсан хэсгээс зохих шийдвэрийн дагуу сургалт арга хэмжээний зардалд зориулан 3.0 сая төгрөгийн, өөрийн орлогын давсан хэсгээс 15.6 сая төгрөгийн, нийтдээ 18.6 сая төгрөгийн орлогыг хүлээн авч тавилга, тоног төхөөрөмж багаж хэрэгсэл худалдан авахад 11.3 сая төгрөг, цалин урамшуулал, НДШ-д 4.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсээс бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр асуудал үүсээгүй болно.

Стандарт хэмжилзүйн хэлтэс нь 2021 онд гүйцэтгэлээр 191648.3 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д заасаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 23030.0 мянган төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувиар буюу 2303.0 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй, санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 117 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

Тайлант оны таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 49.5 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 70% -тай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнээд зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөгдөв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд тус байгууллагад Төрийн аудитын байгууллагаас итгэл үзүүлсэн тул санхүүгийн тайлангийн аудитад ороогүй зөвлөмж өгөгдөөгүй байна

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 69.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 51.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 18.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 51.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант оны таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогыг 49.5 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч

хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 70% -тай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.4, 6.4.6, 6.4.8 дахь заалтууд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 70 % -тай байгаа тул зөрчлийг арилгуулах талаар албан шаардлага өгөв.

2. Стандарт хэмжилзүйн хэлтэс нь тайлант онд гүйцэтгэлээр 191.6 сая төгрөгийг зарцуулснаас 168.3 сая төгрөг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой цалин, тогтмол зардал, багаж хэрэгслийн зардлууд байна.

Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 43 дугаар тогтоолд заасны дагуу шалгахад тэвчиж болох бусад урсгал зардал 23.3 сая төгрөгийг 10 хувь буюу 2.3 сая төгрөгөөр хэмнэж ажиллах ёстой боловч хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тэвчиж болох зардлаас хэмнэж зарцуулаагүй 2.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*1.* Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

*1.1.* *Илрүүлэлт:*

Байрны түрээсийн төлбөрт жилийн турш шилжүүлсэн 18.0 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

*1.2.* *Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2,14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 дэх заалтуудыг мөрдөж байрны түрээсийн зардлын гүйлгээг өглөг дансаар тооцоо үүсгэж, бүртгэж тайлагнах, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/**

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Аймгийн СХЗХэлтэс | 3 | 69.8 | | | | | 2 | 51.8 | 1 | 18.0 |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2022.02.25 № 142

танай____________-ны № ____________-т

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Х.ТИЛЕГЕН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН